



ДҮНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар A/86

Мандалговь

Г Эрсдэлт нөхцөлд амьдарч буй өрхүүдэд  
"Хүнсний багц" олгох тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгын газрын 201 дүгээр тогтоол "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам"-ын 3.1 дэх хэсэг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн "Хүүхдийн эрхийг хамгаалах урьдчилан сэргийлэх тухай" 02 дугаар албан даалгавар, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн улс орнуудад шинэ төрлийн корона вирус дэгдсэнтэй холбогдуулан халдварт авах эрсдлээс урьдчилан сэргийлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа гэр бүлүүдэд "Хүнсний багц" олгох ажлыг 2020 оны 12 дугаар сарын 07-31-ний өдрийн дотор зохион байгуулсугай.

2. Эрсдэлт нөхцөлд амьдарч буй өрхүүдэд "Хүнсний багц" олгох ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 15086400 (Арван таван сая наян зургаан мянга дөрвөн зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлж, 11 өрхөд олгох хүнсний дэмжлэгийг Хулд сумын Засаг даргын Тамгын газарт олгохыг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсгүй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам), гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ



18119077